



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/117

Мандалговь

Хүүхдийн урлагийн бага наадам  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/а/, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2, 17 дугаар зүйлийн 17.1.2, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, 14.2.2, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.8, 16.1.10, 16.1.12, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.5, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Зууны манлай Алдарт уртын дуучин Ж.Дорждагвын нэрэмжит Хүүхдийн урлагийн бага наадмыг аймгийн Засаг даргын ивээлд дор 2018 оны 05 дугаар сард багтаан зохион байгуулсугай.

Хоёр. Хүүхдийн урлагийн бага наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

|                       |                |                                                    |
|-----------------------|----------------|----------------------------------------------------|
| Ажлын хэсгийн ахлагч: | А.Нарантуяа    | Нийгмийн бодлогын хэлтсийн дарга                   |
| Нарийн бичгийн дарга: | Ц.Ганзориг     | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга |
| Гишүүд:               | М.Болор-Эрдэнэ | Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн       |
|                       | Ц.Бумангэрэл   | Боловсрол, соёл урлагийн газрын дарга              |
|                       | А.Ууганбаяр    | "Тэнгэрийн тэмдэг" хүүхдийн театрын захирал        |
|                       | Х.Цогзолмаа    | Боловсрол соёл урлагийн газрын мэргэжилтэн         |

Гурав. Хүүхдийн урлагийн бага наадмын удирдамжийг хавсралтаар баталсугай.

Дөрөв. Хүүхдийн урлагийн бага наадмыг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулж, тайланг 2018 оны 05 дугаар сарын 10-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /А.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О. БАТ-ЭРДЭНЭ



0209386

Аймгийн Засаг даргын 2018 оны  
03 дугаар сарын 04 өдрийн  
А/З тоот захирамжийн хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРААС  
ЗОХИОН БАЙГУУЛЖ БУЙ ХҮҮХДИЙН УРЛАГИЙН ИХ-НААДМЫН ХҮРЭЭНД  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ИВЭЭЛ ДОР ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ  
ЗУУНЫ МАНЛАЙ АЛДАРТ УРТЫН ДУУЧИН Ж.ДОРЖДАГВЫН НЭРЭМЖИТ  
ХҮҮХДИЙН УРЛАГИЙН БАГА НААДМЫН УДИРДАМЖ**

**Зорилго:** Хүүхэд багачуудын авьяасыг нээн илрүүлж, соёлын биет бус өвийг өвлүүлэн хөгжүүлэх, улмаар аймгийн брэнд уртын дуу, морин хуур, ардын язгуур урлагийг түгээн дэлгэрүүлж, сурталчлахад оршино.

**Хамрах хүрээ:** Аймгийн 15 сумын ЕБС-ийн 1-12 дугаар ангийн болон МСҮТ-ийн суралцагсад

**Хаана:** Дундговь аймгийн Хүүхдийн ордон

**Хугацаа:** 2018 оны 05 дугаар сарын 3-4-ний өдөр

**Бүртгэл:** Сайнцагаан сумын ЕБС-иас оролцогчдыг 2018 оны 04 сарын 28-ны өдрийн 10<sup>00</sup>-17<sup>00</sup> цаг хүртэл хүүхдийн театрын 205 тоот өрөөнд бүртгэж, мандат олгоно. Хөдөө орон нутгийн оролцогчдыг 04 сарын 29-30-ны өдөр хүртэл [Graceful\\_2479@yahoo.com](mailto:Graceful_2479@yahoo.com) гэсэн Е-мэйл хаягаар мэдүүлгийг хүлээн авна.

**Шалгаруулалт:** Уралдааныг 3-5 хүний бүрэлдэхүүнтэй мэргэжлийн шүүгчид шүүж явуулна.

**Зохион байгуулалт:**

1. Оролцогчдын хоол, ирж, буцах унааны зардлыг сум, сургууль хариуцна.
2. Урлагийн наадамд оролцогч хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор МСҮТ-ийн дотуур байранд байрлуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч байгаа тул цагаан хэрэглэл, ариун цэврийн хэрэгслийг бэлдэж ирнэ.
3. Байрны төлбөр 1 том өрөө өдрийн 30000 төгрөг байхаар тооцоолж ирнэ.
4. Техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан, хүн тээвэрлэх эрх бүхий жолоочтой тээврийн хэрэгсэлд суудлын тоогоор хүүхдийг суулгана.
5. Шөнө оройн цагаар замд гарахгүй байх
6. Уралдааны үеэр оролцогч хүүхдүүдийн аюулгүй байдалд хараа хяналт тавьж байх эцэг эх, асран хамгаалагч, багш, албан тушаалтныг авч ирнэ.
7. Хүүхэд хамгааллын бодлогыг хүүхэд тус бүр дээр бөглөж, эцэг эх, оролцогч хүүхдээс зөвшөөрөл авсан байна. /Хавсралт-1/

**Уралдааны төрөл:**

**1. Монгол ардын уртын дуу**

Монгол ардын уртын дуу нь хамтлаг төрлөөр явагдана. Хамтлаг төрөл нь "Авьяас" хөтөлбөрийн хүрээнд дугуйланд хамрагдсан 20 хүүхдийн бүрэлдэхүүнтэй байх бөгөөд хүйсийн харьцааг харгалзах нь зүйтэй. Хамтлагийг дугуйлангийн удирдагч багш дагаж

ирнэ. Хамтлаг нь үндэсний урлагийн хувцсаар жигдэрсэн байна. Хамтлаг дуучид нь "Энх мэндийн баяр" дууг заавал сурч дуулах бөгөөд мөн бэсрэг дуунаас сонгож дуулна.

## **2. Үндэсний хөгжим**

Үндэсний хөгжмийн хамтлаг төрөлд ёочин, шанз, хуучир, ятга, лимбэ, морин хуур, их хуур, үлээвэр гэх мэт хөгжмөөр оролцох ба Төрийн шагналт Б.Шарав "Сэрсэн тал" зохиолыг заавал тоглоно. Үндэсний хөгжмийн хамтлагт компьютер хөгжмийг давхар тоглуулахгүй.

## **3. Морин хуур**

Морин хуурын чуулга нь 15-аас дээш хүүхдийн бүрэлдэхүүнтэй, удирдсан багшийн хамт ирнэ. Чуулгын хүүхдүүд үндэсний урлагийн хувцсаар жигдэрсэн байна.

Морин хуурын чуулгын хүүхдүүд нь МУСТА Г.Төвшинтөрийн зохиол "Миний Дундговь" магтаалыг дуулж хуурдана. Мөн өөрсдийн урын сангаас нэг уран бүтээл нэмж тоглоно.

## **4. Бүжгийн төрөл**

Хамтлаг болон гоцлол бүжгийн төрөлд зөвхөн Монгол ардын бүжгээр оролцоно. Хамтлаг ардын бүжгийн төрөл нь 16-аас дээш хүүхдийн бүрэлдэхүүнтэй байх ба хүйс сольж бүжиглэхгүй байх. Цэнгээнт бүжиг болон бусад бүжгийн төрлийг оролцуулахгүй.

## **5. Найрал дуу**

Хүүхэд багачуудын дуулах ур чадварт тохирсон бүхий л төрлийн дуунаас нэгийг сонгон, дөрвөн хоолойгоор дуулна. Хамтлаг нь 16 хүүхдийн бүрэлдэхүүнтэй байх ба өөрсдийн урын сангаас дуулна.

## **6. Трио, Квартет хамтлаг**

Хамтлаг нь өөрсдийн урын сангаас сонгож 2-4 хоолой салгаж дуулна.

## **7. Тууль /хамтлаг/**

Тууль хамтлаг нь 4-өөс дээш хүүхдийн бүрэлдэхүүнтэй байх ба өөрсдийн урын сангаас бэлтгэн оролцоно.

## **8. Циркийн төрөл**

Циркийн ямар ч төрлөөр оролцож болно. Оролцогчдын үзүүлбэрийн аюулгүй байдлыг багш нар бүрэн хариуцна.

## **Наадмын шалгуур үзүүлэлтүүд:**

- Уран бүтээлийн сонголт хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон байх.
- Бүтээлийг өөрийн болгон эзэмшсэн байх.
- Бэлтгэл сургуулилт хангагдсан байх.
- Бүтээлийн гүйцэтгэл, ур чадвар, тайзны соёл, дарааллын цаг баримтлал гэх мэт тухай үеийн шүүгчдээс тавьсан бусад шалгуур үзүүлэлтүүдийг нэмж дүгнэнэ.

**Шагнал урамшуулал:** 2018 оны 05 сарын 05-ны өдрийн Гала тоглолтод төрөл тус бүрийн шагналыг гардуулна.

- 1-р байр -1. Алтан медаль, Өргөмжлөл, мөнгөн шагнал
- 2-р байр -1. Мөнгөн медаль, Өргөмжлөл, мөнгөн шагнал
- 3-р байр -1. Хүрэл медаль, Өргөмжлөл, мөнгөн шагнал
- Тусгай байр -1 Өргөмжлөл, мөнгөн шагнал



Жич: Хүүхдийн урлагийн бага наадамд шалгарсан хамтлаг, гоцлол номерууд телевизийн бичлэгт орж, 3-р шатны шалгаруулалтад оролцоно. 3-р шатны шалгаруулалтад тэнцсэн хүүхдүүдийг улсын баяр наадмын төрийн хүндэтгэлийн тоглолтод оролцох эрхээр шагнана.

Хүүхдүүдээ сайн зохион байгуулж оролцсон багш, сургууль хамт олонд:

1-р байр -1. Цом, Өргөмжлөл, мөнгөн шагнал

2-р байр -1. Цом, Өргөмжлөл, мөнгөн шагнал

3-р байр -1. Цом, Өргөмжлөл, мөнгөн шагнал

**Хамтран зохион байгуулагч:**

- Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар
- Боловсрол, соёл, урлагийн газар
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
- Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр
- Сайхан-овоо сумын Засаг даргын Тамгын газар
- Ж.Дорждагва сан

Холбоо барих утас: 70593003, 99593003, 80003934, 99599841, 88912737

**ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**